



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2016 оны 6 сарын 30 өдөр

Дугаар А-160

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5, 8 дугаар зүйлийн 2, 19 дүгээр зүйлийн 1, 20 дугаар зүйлийн 3, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төлбөрийн картын журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Дээрх журмын 5.2.3, 5.2.4, 5.2.5.6 дэх заалтыг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2009 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн 440, 2011 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 553, 2013 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А-6, 2013 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А-243, 2014 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А-219 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. “Төлбөрийн картын журам”-ыг мөрдөж ажиллахыг Төлбөр тооцоо, бүртгэлийн газар (М.Амгалан), банкуудын гүйцэтгэх захирал нарт тус тус даалгасугай.

5. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн газар (Х.Дэлгэр), Төлбөр тооцоо, бүртгэлийн газар (М.Амгалан)-т тус тус үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.ЗОЛЖАРГАЛ

14 1123

Монголбанкны Ерөнхийлөгчийн
2016 оны 6 дугаар сарын 30 ны
өдрийн 1:160 дугаар тушаалын
хавсралт



ТӨЛБӨРИЙН КАРТЫН ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5 дахь заалт, 8 дугаар зүйлийн 2 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 1 дэх заалтын дагуу төлбөрийн карт (цаашид “карт” гэх)-ын Монгол улсын нутаг дэвсгэр дэх үйл ажиллагааг зохицуулах, зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, оролцогчийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавихад оршино.
- 1.2. Картын үйл ажиллагаанд Иргэний хууль, Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, энэхүү журам, Монголбанкнаас гаргасан холбогдох журмыг удирдлага болгоно.
- 1.3. Картын үйл ажиллагаанд оролцогч нь олон улсад зөвшөөрөгдсөн стандарт, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.
- 1.4. Картын үйл ажиллагаанд оролцогч нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр картаар хийгдэх санхүүгийн гүйлгээг төгрөгөөр гүйцэтгэнэ.
- 1.5. Картын системд ашиглагдаж байгаа програм хангамж нь оюуны өмчийн, лицензийн болон аливаа зөрчилгүй байна.

ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 2.1. Энэхүү журамд хэрэглэгдэх нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:
 - 2.1.1. “Автомат теллер машин” (цаашид “АТМ” гэх) гэж карт хүлээн авагчийн системд холбогдсон, картаар идэвхжиж гүйлгээ хийдэг цахим мэдээ үүсгэгч төхөөрөмжийг;
 - 2.1.2. “Ажлын өдөр” гэж хуульд заасан нийтээр амрах баярын өдөр, амралтын өдрөөс бусад өдрийг;
 - 2.1.3. “АТМ-ийн гүйлгээ” гэж АТМ-аар хийгдэх дараах гүйлгээг:
 - а) картын дансны бэлэн мөнгөний орлого, зарлагын гүйлгээ;
 - б) санхүүгийн бус гүйлгээ;
 - в) олон улсын стандарт болон журмын 2.1.35-д тодорхойлсон сүлжээний дүрэмд нийцсэн бусад гүйлгээ.
 - 2.1.4. “Биет карт” гэж ISO/IEC 7810 ID-1 стандартын бэлдэц дээр картын мэдээллийг хэвлэсэн картыг;
 - 2.1.5. “Биет бус карт” гэж картын гүйлгээнд ашиглагдах биетээр хэвлэгдээгүй картын мэдээллийн цогцыг;
 - 2.1.6. “Бодит цагийн горим” гэж картын гүйлгээг цаг тухайд нь хүлээн авах буюу дамжуулах горимыг;

- 2.1.7. “Түйлгээний баталгаажуулалт” гэж карт эзэмшигч тухайн гүйлгээ, төлбөрийг хүлээн зөвшөөрч, ПИН код оруулах, цахим худалдааны тусгай дугаар (CVV) оруулах, гарын үсгээ зурж баталгаажуулахыг;
- 2.1.8. “Түйлгээний боловсруулалт” гэж картын гүйлгээ, үр дүнгийн тооцооллыг програм хангамжийн тусламжтайгаар гүйцэтгэх;
- 2.1.9. “Түйлгээ дамжуулах өдөр” гэж тухайн өдрийн 00 цагаас дараагийн өдрийн 00 цаг хүртэлх хугацааг;
- 2.1.10. “Түйлгээний зөвшөөрөл” гэж карт ашиглан хийгдэж буй гүйлгээг хийх зөвшөөрөл олгож карт гаргагчийн үүсгэсэн цахим мэдээг;
- 2.1.11. “Гэнэтийн саатал” гэж картын системийн үйл ажиллагаа 2 минутаас дээш хугацаагаар, төлөвлөгөөт бусаар хэсэгчлэн болон бүрэн зогсохыг;
- 2.1.12. “Данс” гэж карт гаргагчаас тухайн картын төлбөр тооцоог хийхэд зориулж нээсэн дансыг;
- 2.1.13. “Зайн унших арга” гэж картын зайн мэдрэгч чипийг цахим мэдээ үүсгэгчид уншуулан картын гүйлгээ үүсгэх аргыг;
- 2.1.14. “Залилан мэхлэх гүйлгээ” гэж бусдын дансанд байгаа мөнгөн хөрөнгийг эзэмших, захиран зарцуулах эрхгүй этгээд итгэл эвдэх буюу хуурч мэхлэх аргаар, санаатайгаар өөрийн эзэмшилд оруулах гүйлгээг;
- 2.1.15. “Залруулгын гүйлгээ” гэж картын үйл ажиллагаанд гарсан алдаатай, маргаантай гүйлгээг шийдвэрлэх зорилгоор карт хүлээн авагчийн үүсгэж буй гүйлгээг;
- 2.1.16. “Карт” гэж карт гаргагчаас банкин дахь данстай нь холбосноор карт эзэмшигчид төлбөр тооцоонд ашиглах боломж олгодог, олон улсад зөвшөөрөгдсөн картын байгууллагын стандарт болон Монголбанкнаас тавьсан шаардлагыг хангасан төлбөрийн хэрэгслийг;
- 2.1.17. “Карт гаргагч” гэж Монголбанкнаас карт гаргах үйл ажиллагааны зөвшөөрөл авсан банкийг;
- 2.1.18. “Карт гаргагчийг таних дугаар” (цаашид “БИН” гэх) гэж карт гаргагч банкийг бусдаас ялгах зорилгоор олон улсад зөвшөөрөгдсөн картын байгууллагаас болон Монголбанкнаас олгосон картын дугаарын хэсэг болох тоон дарааллыг;
- 2.1.19. “Картын гүйлгээ” гэж журмын 2.1.30, 2.1.31-д заасан санхүүгийн болон санхүүгийн бус гүйлгээг;
- 2.1.20. “Картын систем” гэж картын гүйлгээг үүсгэх, дамжуулах, боловсруулахад ашиглаж байгаа програм хангамж, техник тоног төхөөрөмж, холбогдох бодлого, журам, заавар, гэрээний нэгдсэн цогцыг;
- 2.1.21. “Карт хүлээн авагч” гэж Монголбанкнаас карт хүлээн авах үйл ажиллагааны зөвшөөрөл авсан банкийг;
- 2.1.22. “КҮБ” гэж бараа, ажил үйлчилгээний төлбөрийг карт болон цахим мэдээ үүсгэгчийн тусламжтайгаар банкин дахь харилцах дансандаа хүлээн авдаг хувь хүн, хуулийн этгээдийг;
- 2.1.23. “КҮБ-ын шимтгэл” гэж бараа, ажил үйлчилгээний төлбөрийг картын төлбөр тооцооны системээр дамжуулан хүлээж авсны төлөө КҮБ-аас карт хүлээн авагчийн авч буй шимтгэлийг;
- 2.1.24. “Оролцогч” гэж карт гаргагч, карт хүлээн авагч, ҮЦГТ, свитч болон процессорыг;

- 2.1.25. “ПОБ-ын гүйлгээ” гэж ПОБ төхөөрөмж дээр хийгдэх дараах гүйлгээг:
- а) картын дансны бэлэн мөнгөний орлого, зарлагын гүйлгээ;
 - б) санхүүгийн бус гүйлгээ;
 - в) олон улсын стандарт болон журмын 2.1.35-д тодорхойлсон сүлжээний дүрэмд нийцсэн бусад гүйлгээ.
- 2.1.26. “ПОБ төхөөрөмж” гэж карт хүлээн авагч өөрийн салбар, нэгжид байршуулж, системдээ холбосон, картаар идэвхжиж гүйлгээ хийдэг цахим мэдээ үүсгэгч төхөөрөмж болон програм хангамжийг;
- 2.1.27. “ПОС-ын гүйлгээ” гэж ПОС төхөөрөмж дээр хийгдэх дараах гүйлгээг:
- а) худалдан авалтын гүйлгээ;
 - б) гүйлгээний буцаалт;
 - в) үлдэгдэл шалгах;
 - г) бэлэн мөнгө олгох (cashback);
 - д) КУБ-ын хүсэлтээр хийх нэгтгэл гүйлгээ;
 - е) олон улсын стандарт болон журмын 2.1.35-д тодорхойлсон сүлжээний дүрэмд нийцсэн бусад гүйлгээ.
- 2.1.28. “ПОС төхөөрөмж” гэж карт хүлээн авагчийн системд холбогдсон, төлбөр тооцоо хийх зориулалттайгаар КУБ-д байршуулсан, картаар идэвхжиж гүйлгээ хийдэг цахим мэдээ үүсгэгч төхөөрөмж, програм хангамжийн цогцыг;
- 2.1.29. “Процессор” гэж карт хүлээн авагчид картын үйл ажиллагааны техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, сүлжээ, програм хангамж ашиглуулж буй хуулийн этгээдийг;
- 2.1.30. “Санхүүгийн гүйлгээ” гэж цахим мэдээ үүсгэгч ашиглан гүйцэтгэж байгаа мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх үйлдлийг;
- 2.1.31. “Санхүүгийн бус гүйлгээ” гэж цахим мэдээ үүсгэгч ашиглан дансны үлдэгдэл шалгах, ПИН код өөрчлөх, гүйлгээний баримт авах зэрэг мөнгөн дүнгээр үл илэрхийлэгдэх үйлдлийг;
- 2.1.32. “Свитч” гэж карт гаргагч болон карт хүлээн авагчийн хооронд картын төлбөр тооцоог дамжуулах, үр дүнгийн тооцоолол боловсруулах үйл ажиллагааны зөвшөөрлийг Монголбанкнаас авсан хуулийн этгээдийг;
- 2.1.33. “Свитчийн шимтгэл” гэж свитчийн карт гаргагч болон карт хүлээн авагчаас авч буй шимтгэлийг;
- 2.1.34. “Соронзон тууз унших арга” гэж картын соронзон туузыг цахим мэдээ үүсгэгчид уншуулан картын гүйлгээ үүсгэх аргыг;
- 2.1.35. “Сүлжээний дүрэм” гэж ҮЦГТ болон свитчийн ажиллуулж буй банк хоорондын картын төлбөр тооцооны системд холбогдох ашиглагдах техникийн стандарт болон холбогдох гэрээг;
- 2.1.36. “Төрийн үйлчилгээний төлбөр” гэж төрийн үйлчилгээний төлбөр төлөх зорилгоор хийгдэх, үр дүнгийн тооцоолол нь Төрийн сангийн нэгдсэн дансанд тусгагдах картын гүйлгээг;

- 2.1.37. “Төлөвлөгөөт зогсолт” гэж оролцогч нь засвар, үйлчилгээ хийх зорилгоор бусад оролцогчид урьдчилан мэдэгдэж картын системийн үйл ажиллагааг хэсэгчлэн болон бүрэн зогсоохыг;
 - 2.1.38. “Үндэсний төлбөрийн карт” (*цаашид “₮ карт” гэх*) гэж Монголбанкнаас тодорхойлсон стандартыг хангасан, ₮ картын лого бүхий, дотоодод болон олон улсад төлбөр тооцоонд ашиглагдах картыг;
 - 2.1.39. “ҮЦГТ” гэж Монголбанкны Үндэсний цахим гүйлгээний төвийг;
 - 2.1.40. “Хосолсон ₮ карт” гэж карт гаргагч банкнаас олон улсад зөвшөөрөгдсөн картын үйл ажиллагаа эрхлэгч байгууллагатай хамтран гаргасан, тухайн байгууллагын эйквайрингийн сүлжээнд хүлээн авах боломжтой картыг;
 - 2.1.41. “Хувийн таних дугаар” (*цаашид “ПИН код” гэх*) гэж картын гүйлгээг баталгаажуулахад ашиглагдах, зөвхөн тухайн карт эзэмшигч мэдэж байх нууц дугаарыг;
 - 2.1.42. “Хулгайн гүйлгээ” гэж бусдын дансанд байгаа мөнгөн хөрөнгийг эзэмших, захиран зарцуулах эрхгүй этгээд санаатайгаар, нууцаар өөрийн эзэмшилд оруулах үйлдлийг;
 - 2.1.43. “Цахим мэдээ” гэж картын гүйлгээний цахим хэлбэрийг;
 - 2.1.44. “Цахим мэдээ үүсгэгч” гэж карт, картын мэдээлэл ашиглан картын гүйлгээ үүсгэж буй төхөөрөмж, програм хангамжийг;
 - 2.1.45. “Цахим худалдаа” гэж интернэтийн тусламжтайгаар карт ашиглан бараа, ажил үйлчилгээний төлбөр төлөхийг;
 - 2.1.46. “Чип унших арга” гэж картын чипийг цахим мэдээ үүсгэгчид уншуулан картын гүйлгээ үүсгэх аргыг;
 - 2.1.47. “Шууд оролцогч гишүүн” гэж өөрийн болон шууд бус оролцогч гишүүний картын гүйлгээний боловсруулалтыг хийж байгаа, ҮЦГТ-тэй шууд холбогдсон банкийг;
 - 2.1.48. “Шууд бус оролцогч гишүүн” гэж шууд оролцогч гишүүнээр картын гүйлгээний боловсруулалтаа хийлгэдэг, ҮЦГТ-тэй шууд холбогдоогүй банкийг;
 - 2.1.49. “Эзэмшигчийн нэр бичигдээгүй карт” гэж картын нүүрэн талд карт эзэмшигчийн нэр бичигдээгүй картыг;
- 2.2. Энэхүү журамд нийтлэг хэрэглэгдэх нэр томъёог тус журмын 1 дүгээр хавсралтад заасны дагуу англи хэл дээрх утгаар ойлгоно.

ГУРАВ. КАРТ, КАРТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ОРОЛЦОГЧ

- 3.1. Карт гаргагч, хүлээн авагч нь Монголбанкнаас олгосон зөвшөөрлийн дагуу дараах үйл ажиллагааг эрхэлж болно:
 - 3.1.1. Карт гаргах үйл ажиллагаа;
 - 3.1.2. Карт хүлээн авах үйл ажиллагаа;
- 3.2. Карт нь дараах хэлбэртэй байна:
 - 3.2.1. Биет карт;
 - 3.2.2. Биет бус карт.
- 3.3. Карт нь хандаж байгаа данснаас хамаарч дараах төрөлтэй байж болно:

- 3.3.1. Харилцах, хадгаламжийн данс руу шууд хандах боломжтой дебит карт;
- 3.3.2. Гэрээний дагуу олгосон зээлийн эрхтэй кредит карт;
- 3.3.3. Тодорхой зориулалтаар мөнгөн хөрөнгийг урьдчилан байршуулсан данс руу шууд хандах боломжтой урьдчилсан төлбөрт карт.
- 3.4. Карт нь цахим мэдээ үүсгэгч дээр уншигдах аргаас хамаарч дараах төрөлтэй байж болно:
 - 3.4.1. Соронзон туузтай;
 - 3.4.2. Чиптэй;
 - 3.4.3. Зайн мэдрэгчтэй карт.
- 3.5. Карт нь дараах байдлаар хэрэглэгдэж болно:
 - 3.5.1. Картыг биет байдлаар уншуулж ашиглах;
 - 3.5.2. Картын мэдээллийг ашиглах.
- 3.6. Карт нь дор дурдсан үндсэн мэдээллийг агуулна:
 - а) Карт гаргагч, хамтран гаргагчийн нэр, картын таних тэмдэг /лого/, эсхүл олон улсын картын байгууллагын таних тэмдэг /лого/;
 - б) ₮ карт дээр ҮЦГТ-ийн лого;
 - в) Карт эзэмшигчийн нэр/байгууллагын нэр (эзэмшигчийн нэр бичигдээгүй картаас бусад картад хамаарна);
 - в) Монголбанкнаас эсвэл олон улсын картын байгууллагаас олгосон БИН;
 - г) Картын хүчинтэй хугацаа;
 - д) Карт гаргагчийн хаяг, холбоо барих утас, факсын дугаар, цахим шуудангийн хаяг;
 - е) Карт эзэмшигчийн гарын үсэг байрлах хэсэг;
 - ж) Бусад.
- 3.7. Карт ашиглан дараах үндсэн ба нэмэлт гүйлгээг хийнэ:
 - 3.7.1. Үндсэн гүйлгээ:
 - а) АТМ, ПОБ төхөөрөмжийн тусламжтайгаар данснаас бэлэн мөнгөний зарлагын гүйлгээ хийх;
 - б) АТМ, ПОБ төхөөрөмжийн тусламжтайгаар дансны үлдэгдэл шалгах;
 - в) АТМ төхөөрөмжийн тусламжтайгаар гүйлгээний хуулга авах;
 - г) ПОБ төхөөрөмжийн тусламжтайгаар бэлэн мөнгөний орлогын гүйлгээ хийх;
 - д) ПОС төхөөрөмжийн тусламжтайгаар төлбөрийн гүйлгээ хийх, буцаалтын гүйлгээ хийх;
 - е) ПОС төхөөрөмжийн тусламжтайгаар гүйлгээний урьдчилсан зөвшөөрөл авах;
 - ж) ПОС төхөөрөмжийн тусламжтайгаар картын гүйлгээний залруулга хийх;
 - з) Цахим худалдааны гүйлгээ хийх.
 - 3.7.2. Нэмэлт гүйлгээ:
 - а) АТМ төхөөрөмжийн тусламжтайгаар бэлэн мөнгөний орлогын гүйлгээ хийх;
 - б) АТМ төхөөрөмжийн тусламжтайгаар шилжүүлэг хийх;

- в) АТМ, ПОБ төхөөрөмжийн тусламжтайгаар төлбөр төлөх;
- г) АТМ, ПОБ төхөөрөмжийн тусламжтайгаар ПИН код солих;
- д) АТМ, ПОБ төхөөрөмжийн тусламжтайгаар буцаалт болон хэсэгчилсэн буцаалтын гүйлгээг хийх;
- е) Олон улсын стандарт болон ҮЦГТ-ийн сүлжээний дүрэмд нийцсэн бусад гүйлгээ.

3.8. Картын үйл ажиллагаанд дараах талууд оролцоно:

- 3.8.1. ҮЦГТ;
- 3.8.2. Карт гаргагч;
- 3.8.3. Карт хүлээн авагч;
- 3.8.4. Карт эзэмшигч;
- 3.8.5. КУБ;
- 3.8.6. Свитч;
- 3.8.7. Процессор.

ДӨРӨВ. КАРТ ГАРГАГЧИД ТАВИХ ШААРДЛАГА

4.1. Карт гаргагч дараах шаардлагыг хангасан байна:

- 4.1.1. Банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байх;
- 4.1.2. Үр дүнгийн тооцоолол хийх зориулалт бүхий дансыг Монголбанкинд нээсэн байх;
- 4.1.3. Төлбөрийн карт гаргах үйл ажиллагааны зөвшөөрлийг энэхүү журам болон холбогдох хууль тогтоомжийн дагуу Монголбанкнаас авсан байх;
- 4.1.4. Картын үйлчилгээ үзүүлэх тусгай нэгж, газар хэлтэстэй байх.

4.2. Карт гаргагч дараах үүрэгтэй:

- 4.2.1. Карт гаргах үйл ажиллагааны зөвшөөрлийг Монголбанкнаас авсан өдрөөс эхлэн 6 сарын дотор тухайн картын гүйлгээг ҮЦГТ-ийн сүлжээгээр дамжуулах боломжоор хангах.
- 4.2.2. Карт эзэмшигчийн өмнө:
 - а) Карт эзэмшигчтэй гэрээ байгуулах;
 - б) Гүйлгээний зөвшөөрөл олгох болон гүйлгээний боловсруулалтыг тасралтгүй үзүүлэх;
 - в) Хувийн нууцад хамаарах мэдээллийг хууль тогтоомж болон энэ журамд зааснаас бусад зориулалтаар ашиглахгүй байх;
 - г) ПИН кодыг эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр бусдад мэдээлэхгүй байх;
 - д) Картыг шинээр олгохдоо шуудан, интернэт, гар утас болон холбооны бусад хэрэгслээр дамжуулан олгож байгаа тохиолдолд карт эзэмшигчид ПИН кодыг битүүмжилсэн байдлаар тусад нь хүлээлгэн өгөх;
 - е) ₮ картыг шинээр олгохдоо дотоодын цахим худалдааны эрхийг нээсэн байх;
 - ж) Карт эзэмшигч картыг хүлээж авсан буюу хүлээн авснаа мэдэгдсэнээс хойш идэвхжүүлж байх;

- з) Карт, ПИН код алдагдсан нь эзэмшигчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалсан эсэхээс үл хамааран энэ журмын 4.5.8-ын а, б, в-д заасан мэдэгдлийг карт эзэмшигчээс хүлээн авсан даруй гүйлгээний эрхийг хааж, цаашдын алдагдлаас сэргийлэх;
- к) Карт гаргагч нь карт эзэмшигчийн данснаас эрх олгогдоогүй шилжүүлэг хийгдсэн, хийгдэж болзошгүйг мэдсэн үеэс эхлэн журмын 4.2.2-ын з-д заасан үүргийг хүлээх;
- и) Карт эзэмшигчийн мэдэгдлийн дагуу авах арга хэмжээ, шийдвэрлэх хугацааг тодорхой тусгасан журамтай байх, түүнийг карт эзэмшигчид танилцуулах, мэдэгдлийн хариу өгөх хугацааг гэрээнд тусгах, заасан хугацаанд багтаан хариу өгөх;
- л) Карт эзэмшигчийн данс руу хийх орлогын болон зарлагын гүйлгээ, ПОБ төхөөрөмжийн тусламжтайгаар хийх үйлчилгээг өөрийн бүх салбар, тооцооны нэгжээр үзүүлэх;
- м) Карт эзэмшигчид гүйлгээ хийгдсэн эсэх мэдээллийг үнэ төлбөргүй мэдэгдэх сувагтай байх.

4.2.3. Карт хүлээн авагчийн өмнө:

- а) Сэжигтэй картын талаарх мэдээллээр хангах;
- б) Карт гаргагч нь карт эзэмшигчээс журмын 4.5.8-ын а, б, в-д заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш хуурамч болон залилан мэхлэх шинжтэй гүйлгээ хийх зөвшөөрөл өгснөөс үүсэх хохирлыг хариуцах;
- в) Карт хүлээн авагчийн үүсгэсэн маргааныг хамтран ажиллах гэрээнд заасны дагуу шийдвэрлэх;
- г) КҮБ-ын шимтгэлийг ҮЦГТ болон свитчтэй байгуулсан гэрээнд заасан хуваах зарчмын дагуу төлөх;
- д) Карт хүлээн авагчийн гүйлгээнд гэрээнд заасан хугацааны дотор хариу өгөх.

4.2.4. Свитчийн өмнө:

- а) Хамтран ажиллах гэрээ байгуулах, түүнийг даган мөрдөх;
- б) Свитчийн шимтгэл хуваах зарчмыг даган мөрдөх;
- в) Свитчээр дамжсан картын гүйлгээний маргааныг гэрээнд заасан хугацаанд багтаан шийдвэрлэх;
- г) Картын БИН-г гэрээнд заасан хугацаанд бүртгэх, бүртгүүлэх;
- д) Картын гүйлгээнд гэрээнд заасан хугацааны дотор хариу өгөх.

4.3. Карт гаргагч нь журмын 3.2, 3.3, 3.4-т заасан картыг гаргах эрхтэй.

4.4. Карт гаргагч нь Монголбанкинд холбогдох мэдээллийг ирүүлэн дүгнэлт гаргуулсны үндсэн дээр аливаа хуулийн этгээдтэй хамтран ко-бренд карт гаргаж болно.

4.5. Карт гаргагч нь карт эзэмшигчтэй байгуулсан гэрээнд дараах зүйлийг заавал тусгана:

- 4.5.1. Тухайн төлбөрийн картын тодорхойлолт, ашиглаж болох төхөөрөмж, хэрэгсэл, ашиглах арга, гүйцэтгэж болох үйлдлийн төрөл, гүйлгээний үнийн дүнгийн болон давтамжийн хязгаарлалт байгаа бол түүнийг;
- 4.5.2. Карт гаргагч, хүлээн авагч болон эзэмшигчийн эрх үүрэг, хариуцлага;

- 4.5.3. Картыг ашиглахтай холбогдсон үйлчилгээний хураамж, хүү байх бол түүнийг:
- а) Элсэлтийн болон жилийн хураамжийн хэмжээ;
 - б) Гүйлгээний шимтгэлийн төрөл, хэмжээ;
 - в) Хүүгийн хэмжээ болон хүү тооцох аргачлал.
- 4.5.4. Журмын 4.5.3-т заасан үйлчилгээний хураамж, хүүг карт эзэмшигчийн данснаас суугтах нөхцөл, хугацааны талаарх мэдээлэл;
- 4.5.5. Гомдол, маргаан үүсгэх эрх, хугацааны хязгаар, гаргах хэлбэр;
- 4.5.6. Карт нь гадаадад ашиглах эрхтэй бол гүйлгээний шимтгэл, хураамж, хөрвүүлэх ханш, дансанд тусгах хугацаа;
- 4.5.7. Карт гаргагч нь гэрээнд өөрчлөлт оруулах талаар карт эзэмшигчид хуанлийн 30 /гуч/ хоногийн өмнө мэдэгдсэнээр гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулах эрхтэй. Заасан хугацаанд карт эзэмшигч гэрээнээс татгалзаагүй бол, гэрээний өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөнд тооцох тухай;
- 4.5.8. Гэрээнд карт эзэмшигчийн хүлээх дараах үүргийг заавал тусгана:
- а) Карт буюу ПИН кодыг хаяж үрэгдүүлсэн, хулгайд алдсан тохиолдолд банкинд нэн даруй мэдэгдэх;
 - б) Өөрийн данснаас эрх олгогдоогүй шилжүүлэг хийгдсэн болон бүртгэлийн аливаа алдаа, зөрчил дутагдлыг илрүүлсэн тохиолдолд банкинд нэн даруй мэдэгдэх;
 - в) Өөрийн ПИН кодыг гуравдагч этгээд мэдсэн байж болзошгүй гэж үзсэн тохиолдолд банкинд нэн даруй мэдэгдэх;
 - г) Картыг бусдад ашиглуулахгүй байх;
 - д) ПИН кодоо нууцлах;
 - е) Гэрээгээр заасан үүргээ биелүүлэх.
- 4.6. Карт эзэмшигч журмын 4.5.8-ын а, б, в-д заасан мэдэгдлийг өөрийн биеэр, бичгээр, утсаар өгч болно.

ТАВ. КАРТ ХҮЛЭЭН АВАГЧИД ТАВИХ ШААРДЛАГА

- 5.1. Карт хүлээн авагч дараах шаардлагыг хангасан байна:
- 5.1.1. Банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байх;
 - 5.1.2. Үр дүнгийн тооцоолол хийх зориулалт бүхий дансыг Монголбанкинд нээсэн байх;
 - 5.1.3. Төлбөрийн карт хүлээн авах зөвшөөрлийг энэхүү журам болон холбогдох хууль тогтоомжийн дагуу Монголбанкнаас авсан байх;
 - 5.1.4. Картын үйлчилгээ үзүүлэх тусгай нэгж, газар хэлтэстэй байх.
- 5.2. Карт хүлээн авагч дараах үүрэгтэй:
- 5.2.1. Энэ журмын 3.7.1-д заасан картын үндсэн гүйлгээг хийх боломжийг өөрийн болон бусад банкны карт эзэмшигчид олгох.
 - 5.2.2. Шууд болон шууд бус оролцогч гишүүний гаргасан картаар хийгдэх банк хоорондын дотоодын гүйлгээг ҮЦГТ болон свитчээр дамжуулан гүйцэтгэх.

- 5.2.3. Шинээр оруулж ирж байгаа ПОС төхөөрөмж нь олон улсын чип EMV (EMV contact Level 1, Level 2 type approval) стандартын сертификаттай байх.
[/Энэ заалтыг 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлнэ./](#)
- 5.2.4. Шинээр оруулж ирж байгаа зайн мэдрэгч унших боломжтой ПОС төхөөрөмж нь олон улсын зайн EMV (EMV contactless Level 1, Level 2 type approval) стандартын сертификаттай байх.
[/Энэ заалтыг 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлнэ./](#)
- 5.2.5. Картын 5000 (таван мянган) хүртэлх төгрөгийн дүнтэй гүйлгээнээс баталгаажуулалт шаардахгүй байж болох ба 5000 (таван мянган) төгрөгөөс дээш дүнтэй гүйлгээнд заавал баталгаажуулалт шаардах.
- а) Баталгаажуулалт хийгдээгүй гүйлгээнээс гарах эрсдэлийг карт хүлээн авагч хариуцна;
- б) ПОС-ын гүйлгээг ПИН кодоор баталгаажуулна;
[/Энэ заалтыг 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлнэ./](#)
- в) ПИН кодоор баталгаажуулсан гүйлгээнд гарын үсэг шаардахгүй байж болно;
- г) Журмын 3.5.2-т заасан картын мэдээлэл ашиглах гүйлгээ болон биет бус картын гүйлгээг зөвхөн ПИН кодоор баталгаажуулна.
- 5.2.6. Карт гаргагчийн өмнө:
- а) КҮБ нь карт эзэмшигчийн гарын үсгийг шалгаагүй, картын эзэмшлийг тодорхойлоогүйгээс гарсан хуурамч болон залилан мэхлэх шинжтэй гүйлгээнээс үүсэх хохирлыг шийдэх;
- б) Карт гаргагчийн үүсгэсэн маргааныг хамтран ажиллах гэрээнд заасны дагуу шийдвэрлэх;
- в) КҮБ-ын шимтгэлийг ҮЦГТ болон свитчтэй байгуулсан гэрээнд заасан хуваах зарчмын дагуу төлөх.
- 5.2.7. Карт хүлээн авагч нь зөвхөн худалдаа, үйлчилгээ эрхэлдэг хувь хүн, хуулийн этгээдийг КҮБ-аар элсүүлэн, гэрээ байгуулна.
- 5.2.8. КҮБ-ын өмнө:
- а) Үйлчилгээний нөхцөлийг тодорхой заасан гэрээ байгуулах;
- б) КҮБ-ыг ПОС төхөөрөмж дээр ажиллаж сургах;
- в) Хуурамч болон залилан мэхлэх шинжтэй гүйлгээ илрүүлсэн тохиолдолд шуурхай арга хэмжээ авах;
- г) КҮБ-ын үүсгэсэн маргааныг дор бүр нь судалж, гэрээнд заасан хугацаанд шийдвэрлэх;
- д) ПОС дээр хийгдсэн гүйлгээнд заасан хугацааны дотор хариу өгөх;
- е) ПОС төхөөрөмжийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах;
- ж) Хуурамч болон залилангийн гүйлгээнээс урьдчилан сэргийлэх зорилгоор заавар зөвлөмжөөр хангах.
- 5.2.9. КҮБ-тай байгуулах гэрээнд дараах зүйлсийг заавал тусгана:
- а) Картыг бэлэн мөнгөний нэгэн адил тооцож ижил үнээр төлбөрт хүлээн авах;
- б) Карт эзэмшигчээс картаар үйлчилсний нэмэлт шимтгэл авахгүй байх;

- в) Картыг эзэмшигчийн дэргэд ПОС төхөөрөмж дээр уншуулах;
 - г) Карт эзэмшигч ПИН кодыг зөвхөн өөрөө оруулах боломжоор хангах;
 - д) Төлбөрийн ямар хэрэгсэл ашиглахыг хэрэглэгчээс лавладаг байх;
 - е) Картын гүйлгээний үр дүнгийн тооцооллыг банкин дахь харилцах дансаар хүлээн авах;
 - ж) ПОС төхөөрөмжийг Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглах бөгөөд зөвхөн гэрээнд заасан байршилд буюу урьдчилан тодорхойлсон нутаг дэвсгэрийн хүрээнд байршуулах;
 - з) ПОС төхөөрөмжийн эзэмшигч болон ашиглах байршил өөрчлөгдөх тухай бүрт гэрээг шинэчлэн байгуулах;
 - и) Карт эзэмшигчийн гарын үсгийг шалгаж, тухайн картыг эзэмшигч мөн эсхийг баталгаажуулах, баталгаажуулаагүйн улмаас үүсэх хохирлыг КУБ хариуцах.
- 5.2.10. КУБ-д тавигдах шаардлагыг хангуулж, хяналт тавих.
- 5.2.11. КУБ-ын картын төлбөр тооцоотой холбоотой үйл ажиллагаанд хяналт тавих.
- 5.2.12. КУБ-ын гүйлгээг залилан буюу луйврын шинж чанартай гэж сэжиглэсэн тохиолдолд тухайн гүйлгээг КУБ-тай хийх тооцоонд оруулалгүй, маргаан шийдэгдэх хүртэл дансанд хөдөлгөөнгүйгээр барих.
- 5.2.13. Свитчийн өмнө:
- а) Хамтран ажиллах гэрээ байгуулах, түүнийг даган мөрдөх;
 - б) Свитчийн тогтоосон КУБ-ын шимтгэл хуваах зарчмыг мөрдөх;
 - в) Свитчээр дамжсан картын гүйлгээний маргааныг гэрээнд заасан хугацаанд багтаан шийдвэрлэх;
 - г) БИН дугаар бүртгэх, бүртгүүлэх.
- 5.2.14. Шинээр суурилуулж байгаа болон өөрчлөлт хийж байгаа цахим мэдээ үүсгэгчид ҮЦГТ-өөс ашиглалтын дүгнэлт авах (цахим мэдээ үүсгэгчийн загварыг тестэлнэ).
- 5.2.15. Цахим мэдээ үүсгэгч дээр ҮЦГТ-ийн логог карт эзэмшигчид харагдахуйцаар байршуулах.
- 5.2.16. Энэ журмын 3 дугаар хавсралтад заасны дагуу цахим мэдээ үүсгэгч төхөөрөмжид тавигдах шаардлагыг хангаж ажиллах.
- 5.3. Карт хүлээн авагч нь КУБ дээр тавигдсан терминалын тохиргоонд тухайн КУБ-ын үйл ажиллагааны ангилал код (Merchant category code)-ыг 2 дугаар хавсралтад заасны дагуу бүртгэж, үнэн зөв оруулна.
- 5.4. Карт хүлээн авагч нь процессортой хамтран ажиллах зөвшөөрлийг Монголбанкнаас авна.
- 5.5. Карт хүлээн авагч нь гүйлгээний боловсруулалтаа процессороор хийлгэж байгаа тохиолдолд процессорт карт хүлээн авах үйл ажиллагааны болон санхүүгийн баталгаа гаргана.
- 5.6. Карт хүлээн авагч нь энэхүү журмын 7-р бүлэгт заасан шаардлагыг өөрийн хамтран ажиллаж байгаа процессороор хангуулна.

ЗУРГАА. СВИТЧИД ТАВИХ ШААРДЛАГА

- 6.1. Свитч дараах шаардлагыг хангасан байна:
 - 6.1.1. Банк хооронд картын гүйлгээний боловсруулалт хийх үйл ажиллагааны зөвшөөрлийг энэхүү журам болон холбогдох хууль тогтоомжийн дагуу Монголбанкнаас авсан байх;
 - 6.1.2. Сүлжээний дүрмийг Монголбанкаар хянуулсан байх;
 - 6.1.3. Шууд болон шууд бус оролцогчийн үр дүнгийн тооцооллыг Монголбанкин дахь тухайн оролцогчийн харилцах дансаар гүйцэтгэх боломжийг хангасан байх.
 - 6.1.4. Өөрийн сүлжээний оролцогч бүх банкинд ижил шимтгэл, нөхцөл бүхий дүрэм тогтоох.
- 6.2. Свитч нь өөрийн системд мөрдөх эрх зүй, техникийн бодлогыг свитчийн сүлжээний дүрэм, хамтран ажиллах гэрээний тусламжтайгаар хэрэгжүүлнэ.
- 6.3. Свитч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:
 - 6.3.1. Банк хооронд хийх картын гүйлгээний боловсруулалтыг гүйцэтгэх;
 - 6.3.2. Картаар хийгдсэн сэжигтэй гүйлгээний мэдээллийн санг хөтлөн ажиллуулж, оролцогчийн зөвшөөрлөөр уг сангаас холбогдох мэдээлэл өгөх;
 - 6.3.3. Карт гаргагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр түүний өмнөөс гүйлгээний зөвшөөрөл олгох;
 - 6.3.4. Свитчийн үйлчилгээний шимтгэлийг карт гаргагч болон карт хүлээн авагчаас авах.
- 6.4. Свитч дараах үүрэг хүлээнэ:
 - 6.4.1. Карт гаргагч, хүлээн авагч, Монголбанктай гэрээ байгуулах;
 - 6.4.2. Картын гүйлгээний боловсруулалтыг тасралтгүй гүйцэтгэх;
 - 6.4.3. Мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг бүрэн хангасан байх;
 - 6.4.4. Залруулгын гүйлгээ хийх, маргааныг шийдвэрлэх боломжоор хангах, хяналт тавих;
 - 6.4.5. Карт хүлээн авагчийн гүйлгээнд гэрээнд заасан хугацааны дотор хариу өгөх;
 - 6.4.6. Журмын 11 дүгээр хавсралтад заасны дагуу үйл ажиллагааны тайланг долоо хоног тутам гаргаж, Монголбанкинд хүргүүлэх.
- 6.5. Свитч нь өөрийн сүлжээний бүх гишүүн банкинд техникийн ижил шаардлага тавина.
- 6.6. Свитчийн сүлжээний дүрэм, хамтран ажиллах гэрээнд дараах зүйлсийг тусгасан байна:
 - 6.6.1. Гишүүнээр элсэхэд тавигдах шаардлага;
 - 6.6.2. Гишүүн банкны эрх, үүрэг;
 - 6.6.3. Свитчийн системд холбогдох техник, цахим мэдээний стандарт;
 - 6.6.4. Свитчийн үзүүлэх үйлчилгээний жагсаалт, тэдгээрийн дэлгэрэнгүй тайлбар;
 - 6.6.5. Шимтгэлийн хэмжээ, түүнийг хуваарилах зарчим;
 - 6.6.6. Төлбөр тооцоо, үр дүнгийн тооцоолол хийх зарчим, хуваарь;
 - 6.6.7. Маргаан шийдвэрлэх зарчим;
 - 6.6.8. Тасралтгүй ажиллагаа, аюулгүй байдлын үзүүлэлт, тэдгээрийг хангаагүй тохиолдолд авах арга хэмжээ;

6.6.9. Гишүүн банктай байгуулах гэрээний загвар.

- 6.7. Свитч нь сүлжээний дүрэм, хамтран ажиллах гэрээнд орсон өөрчлөлтийг хүчин төгөлдөр болохоос ажлын 15 хоногоос доошгүй хугацааны дотор гишүүн банкинд хүргүүлнэ.
- 6.8. Свитчийн сүлжээний дүрэм, хамтран ажиллах гэрээ нь гишүүн банкинд нээлттэй, ил тод байна.
- 6.9. Банк хоорондын картын төлбөр тооцооны маргааныг шийдвэрлэх зарчмыг свитч тогтоож, маргаанд оролцогчийн эрх, үүрэг, маргаан шийдвэрлэх хугацааг сүлжээний дүрэм, хамтран ажиллах гэрээнд тодорхой тусгана.
- 6.10. Банк хоорондын картын төлбөр тооцооны маргааныг шийдвэрлэсэн свитчийн шийдвэрийг гишүүн банк нь зөвшөөрөхгүй бол Монголбанкинд гомдол гаргаж болно.

ДОЛОО. ПРОЦЕССОРТ ТАВИХ ШААРДЛАГА

- 7.1. Процессор нь карт хүлээн авагчтай хамтран ажиллах гэрээ байгуулсны үндсэн дээр түүний өмнөөс картыг төлбөр тооцоонд хүлээж авна.
- 7.2. Процессор нь дараах шаардлагыг хангасан байна:
 - 7.2.1. Карт хүлээн авагчтай хамтран ажиллах гэрээ байгуулсан байх;
 - 7.2.2. Картын үйлчилгээ үзүүлэх чадвартай мэргэжлийн боловсон хүчинтэй байх;
 - 7.2.3. Монголбанк болон олон улсын картын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагаас шаардах стандартыг мөрдөн ажиллах боломжтой байх;
 - 7.2.4. Энэ журмыг мөрдөн ажиллахыг хүлээн зөвшөөрсөн байх;
 - 7.2.5. Карт хүлээн авах үйл ажиллагааг тасралтгүй, найдвартай явуулахуйц дэд бүтэц, програм хангамжтай байх;
 - 7.2.6. Мэдээллийн нууцлал аюулгүй байдлыг бүрэн хангасан байх;
 - 7.2.7. Банк хоорондын төлбөр тооцоог зөвхөн ҮЦГТ-өөр дамжуулж гүйцэтгэх.
- 7.3. Процессор нь карт хүлээн авагчтай байгуулсан гэрээнд дараах зүйлийг тусгана:
 - 7.3.1. Талуудын эрх, үүрэг, хүлээх хариуцлага;
 - 7.3.2. Үйлчилгээний шимтгэл, түүнийг хуваарилах;
 - 7.3.3. Төлбөр тооцоог бодит цагийн горимоор дамжуулах тухай;
 - 7.3.4. Үр дүнгийн тооцоолол хийх зарчим;
 - 7.3.5. Гомдол, маргаан шийдвэрлэх зарчим;
 - 7.3.6. Үйлчилгээний нууцлал, аюулгүй байдлыг бүрэн хангах тухай;
 - 7.3.7. Үйлчилгээний тасралтгүй, найдвартай байдлыг бүрэн хангах тухай.

НАЙМ. ҮЦГТ-ИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 8.1. ҮЦГТ нь шууд болон шууд бус оролцогч гишүүний картын төлбөр тооцооны үр дүнгийн тооцооллыг Монголбанкн дахь харилцах дансаар гүйцэтгэх боломжтой байна.
- 8.2. ҮЦГТ-ийн сүлжээний дүрмийг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батална.
- 8.3. ҮЦГТ нь өөрийн сүлжээн дэх гишүүдэд ижил хэмжээтэй шимтгэл болон нөхцөл бүхий сүлжээний дүрмийг тогтооно.

- 8.4. ҮЦГТ нь Сангийн яамтай гэрээ байгуулсны үндсэн дээр түүний өмнөөс карт хүлээн авах үйл ажиллагаа эрхэлж болно.
- 8.5. ҮЦГТ нь гишүүдэд картын үйл ажиллагаатай холбоотой нэгдсэн стандартыг мөрдүүлж, системийн нэгдмэл байдлыг хангана.
- 8.6. ҮЦГТ нь мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг бүрэн хангасан байна.
- 8.7. ҮЦГТ нь дараах эрхтэйгээр свитчийн үйл ажиллагаа эрхэлнэ:
 - 8.7.1. Карт гаргагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр түүний өмнөөс гүйлгээний зөвшөөрлийг олгох;
 - 8.7.2. ҮЦГТ-ийн шимтгэлийг карт гаргагч болон карт хүлээн авагчаас авах.
- 8.8. ҮЦГТ нь дараах үүрэгтэйгээр свитчийн үйл ажиллагаа эрхэлнэ:
 - 8.8.1. Карт гаргагч, хүлээн авагчтай хамтран ажиллах гэрээ байгуулах;
 - 8.8.2. Банк хооронд картын гүйлгээний боловсруулалт, дамжуулалтыг гүйцэтгэх;
 - 8.8.3. Картын гүйлгээний боловсруулалтыг тасралтгүй гүйцэтгэх;
 - 8.8.4. Картын гүйлгээний нууцлалыг хангах;
 - 8.8.5. Картаар хийгдсэн сэжигтэй гүйлгээний мэдээллийн санг хөтлөн ажиллуулж, оролцогчийн зөвшөөрлөөр уг сангаас холбогдох мэдээлэл өгөх;
 - 8.8.6. Залруулгын гүйлгээ хийх, картын гүйлгээний маргааныг шийдвэрлэх боломжоор хангах, хяналт тавих;
 - 8.8.7. Карт хүлээн авагчийн гүйлгээнд хамтран ажиллах гэрээнд заасан хугацааны дотор хариу өгөх;
 - 8.8.8. Картын гүйлгээний болон тасралтгүй ажиллагааны тайланг долоо хоног тутам гаргах, оролцогчдыг тайлан, мэдээгээр хангах.
- 8.9. ҮЦГТ нь хамтран ажиллах гэрээ байгуулсны үндсэн дээр карт гаргагч, хүлээн авагч банкинд техник, програм хангамжийн үйлчилгээ үзүүлж болно.
- 8.10. ҮЦГТ-ийн сүлжээний дүрэм, хамтран ажиллах гэрээнд дараах зүйлсийг тусгасан байна:
 - 8.10.1. Гишүүн банкны эрх, үүрэг, хүлээх хариуцлага;
 - 8.10.2. Гишүүнээр элсэхэд тавигдах шаардлага;
 - 8.10.3. ҮЦГТ-ийн системд холбогдох техник, цахим мэдээний стандарт;
 - 8.10.4. Үйлчилгээний жагсаалт, тэдгээрийн дэлгэрэнгүй тайлбар;
 - 8.10.5. Шимтгэлийн хэмжээ, хуваарилах зарчим;
 - 8.10.6. Төлбөр тооцоо, үр дүнгийн тооцоолол хийх зарчим, хуваарь;
 - 8.10.7. Маргаан шийдвэрлэх зарчим;
 - 8.10.8. Тасралтгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангах аргачлал, тэдгээрийг хангаагүй тохиолдолд авах арга хэмжээ;
 - 8.10.9. Гишүүн банктай байгуулах гэрээний загвар.
- 8.11. ҮЦГТ нь сүлжээний дүрэм, хамтран ажиллах гэрээнд оруулах өөрчлөлтийг хүчин төгөлдөр болохоос ажлын 15-аас доошгүй хоногийн өмнө гишүүн банкинд хүргүүлнэ.
- 8.12. ҮЦГТ-ийн сүлжээний дүрэм, хамтран ажиллах гэрээ нь гишүүн банкинд нээлттэй, ил тод байна.

- 8.13. Банк хоорондын төлбөрийн картын гүйлгээний маргаан шийдвэрлэх зарчмыг боловсруулж, маргаанд оролцогчийн эрх, үүрэг, маргааныг шийдвэрлэх хугацааг сүлжээний дүрэм, хамтран ажиллах гэрээнд тодорхой тусгасан байна.

ЕС. КАРТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

- 9.1. Карт гаргах болон хүлээн авах үйл ажиллагааны зөвшөөрөл хүсэгч нь энэ журмын 9.8, 9.9-д заасан баримт бичгийн эх хувийг эсвэл баталгаажуулсан хувийг бүрдүүлж Монголбанкинд ирүүлнэ.
- 9.2. Свитчийн үйл ажиллагааны зөвшөөрөл хүсэгч нь энэ журмын 9.10-д заасан баримт бичгийн эх хувийг эсвэл баталгаажуулсан хувийг бүрдүүлж Монголбанкинд ирүүлнэ.
- 9.3. Монголбанкны Төлбөр тооцоо, бүртгэлийн газрын Төлбөрийн бодлого, зохицуулалтын хэлтэс (цаашид “ТБЗХ” гэх) нь хүсэлт гаргагчаас бүрэн гүйцэд ирүүлсэн баримт бичгийг хүлээж авснаас хойш холбогдох зөвшөөрөл олгох эсэх асуудлыг ажлын 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.
- 9.4. ТБЗХ нь карт гаргах, бүртгэх, эзэмшигчид олгох, гүйлгээний боловсруулалт, дамжуулалт хийх зэрэг картын үйл ажиллагаанд мөрдөх бодлогын болон эрх зүйн баримт бичиг, эзэмшигчтэй байгуулах гэрээний төслийг хянаж, тухайн үйл ажиллагаатай холбогдон гарах эрсдэлүүдийг бууруулах, хянах бололцоотой эсэх байдалд дүгнэлт гаргана.
- 9.5. ТБЗХ нь ирүүлсэн баримт бичиг, техник, програм хангамжийн тодорхойлолт, 9.4-д тодорхойлсон дүгнэлтэд үндэслэн үйл ажиллагааны хэсэгчилсэн зөвшөөрөл олгож болно.
- 9.6. Холбогдох хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн актаар тавьсан шаардлагад нийцээгүй бол свитчийн болон карт гаргах, хүлээн авах үйл ажиллагааны зөвшөөрлийг олгохоос татгалзана.
- 9.7. Свитчийн болон карт гаргах, хүлээн авах үйл ажиллагааны зөвшөөрөл олгох эсэх шийдвэрийг Монголбанкны Ерөнхийлөгч гаргана. Монголбанкнаас зөвшөөрөл олгосон эсэх талаарх хариуг шийдвэр гарснаас хойш хүсэлт гаргагчид ажлын 3 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.
- 9.8. Карт гаргах үйл ажиллагааны зөвшөөрөл хүсэгч банк нь дор дурдсан бичиг баримтын эх хувийг эсвэл баталгаажуулсан хувийг бүрдүүлж, Монголбанкинд ирүүлнэ.
- 9.8.1. Карт гаргах үйл ажиллагааны зөвшөөрөл хүссэн өргөдлийг 4 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу;
- 9.8.2. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн картын байгууллагын гишүүнээр элссэн тохиолдолд тухайн байгууллагын зөвшөөрөл;
- 9.8.3. Техник тоног төхөөрөмж, програм хангамжийн тодорхойлолт (Тодорхойлолтод техник тоног төхөөрөмж, програм хангамжийн гарал үүсэл, загвар, техникийн үзүүлэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл байна);
- 9.8.4. Карт гаргах, бүртгэх, нийтэд тараах зэрэг картын үйл ажиллагаанд мөрдөх бодлогын болон эрх зүйн баримт бичиг (дүрэм, гэрээ гэх мэт);
- 9.8.5. Дараах үйл ажиллагааг зохицуулсан журмууд:
- а) Маргаан шийдвэрлэх;
 - б) Карт хэвлэх, карт эзэмшигчид олгох;
 - в) Нууцлал, аюулгүй байдлын;

- г) Хоорондын тооцооны;
 - д) Картын үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах;
 - е) Мэдээллийн технологийн үндсэн болон нөөц төвийн;
 - ж) Эрсдэлийн удирдлагын;
 - з) Бусад.
- 9.8.6. Картын үйл ажиллагааг хариуцах нэгжийг тодорхойлсон зураглал, ажлын байрны дэлгэрэнгүй тодорхойлолт;
- 9.8.7. Карт гаргах үйл ажиллагааны зөвшөөрөл олгох үйлчилгээний хөлсийг “Монголбанкны үйлчилгээний шимтгэлийн ерөнхий нөхцөл”-ийн дагуу төлсөн баримт;
- 9.8.8. Карт гаргагч нь шууд бус оролцогч бол шууд оролцогчийн зөвшөөрөл;
- 9.8.9. Карт гаргах үйл ажиллагаа эрхлэхэд үүсэж болзошгүй эрсдэлийг даах баталгаа;
- 9.8.10. Шаардлагатай гэж үзсэн бусад баримт бичиг.
- 9.9. Карт хүлээн авах үйл ажиллагааны зөвшөөрөл хүсэгч нь дор дурдсан бичиг баримтыг үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлж, эх хувийг эсвэл баталгаажуулсан хувийг Монголбанкинд ирүүлнэ.
- 9.9.1. Карт хүлээн авах үйл ажиллагааны зөвшөөрөл хүссэн өргөдлийг 4 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу;
- 9.9.2. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн картын байгууллагын гишүүнээр элссэн тохиолдолд тухайн байгууллагын зөвшөөрөл;
- 9.9.3. Карт хүлээн авах үйл ажиллагаанд мөрдөх бодлогын болон эрх зүйн баримт бичиг (дүрэм, гэрээ гэх мэт);
- 9.9.4. Дараах үйл ажиллагааг зохицуулсан журмууд:
- а) Маргаан шийдвэрлэх;
 - б) Нууцлал, аюулгүй байдлын;
 - в) Хоорондын тооцооны;
 - г) Картын үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах;
 - д) Мэдээллийн технологийн үндсэн болон нөөц төвийн;
 - е) Эрсдэлийн удирдлагын;
 - ж) Бусад.
- 9.9.5. Карт хүлээн авах техник тоног төхөөрөмж дэлгэрэнгүй тайлбар, техникийн баримт бичиг, нууцлал, аюулгүй байдлыг хангасан тухай баталгаа;
- 9.9.6. Картын гүйлгээний боловсруулалт хийх системийн дэлгэрэнгүй тайлбар, техникийн баримт бичиг, боловсруулсан компанитай байгуулсан гэрээ;
- 9.9.7. Картын үйл ажиллагааг хариуцах нэгжийг тодорхойлсон зураглал, ажлын байрны дэлгэрэнгүй тодорхойлолт;
- 9.9.8. Карт хүлээн авах үйл ажиллагааны зөвшөөрөл олгох үйлчилгээний хөлсийг “Монголбанкны үйлчилгээний шимтгэлийн ерөнхий нөхцөл”-ийн дагуу төлсөн баримт;

- 9.9.9. Карт хүлээн авах үйл ажиллагаа эрхлэхэд үүсэж болзошгүй эрсдэлийг даах баталгаа;
- 9.9.10. Шаардлагатай гэж үзсэн бусад баримт бичиг.
- 9.10. Свитчийн үйл ажиллагааны зөвшөөрөл хүсэгч нь дор дурдсан баримт бичгийн эх хувийг эсвэл баталгаажуулсан хувийг бүрдүүлж Монголбанкинд ирүүлнэ.
- 9.10.1. Свитчийн үйл ажиллагааны зөвшөөрөл хүссэн өргөдлийг 5 дугаар хавсралтад заасан маягтын дагуу;
- 9.10.2. Свитчийн үйл ажиллагаанд мөрдөх бодлогын болон эрх зүйн баримт бичиг (дүрэм, гэрээ гэх мэт);
- 9.10.3. Дараах үйл ажиллагааг зохицуулсан журмууд:
- а) Маргаан шийдвэрлэх;
 - б) Нууцлал, аюулгүй байдлын;
 - в) Хоорондын тооцооны;
 - г) Тасралтгүй, найдвартай үйл ажиллагааг хангах;
 - д) Мэдээллийн технологийн үндсэн болон нөөц төвийн;
 - е) Эрсдэлийн удирдлагын;
 - ж) Бусад.
- 9.10.4. Свитчийн үйл ажиллагаанд ашиглах техник тоног төхөөрөмжийн дэлгэрэнгүй тайлбар, техникийн баримт бичиг, нууцлал, аюулгүй байдлыг хангасан тухай баталгаа;
- 9.10.5. Картын гүйлгээний боловсруулалт хийх системийн дэлгэрэнгүй тайлбар, техникийн баримт бичиг, боловсруулсан компанитай байгуулсан гэрээ;
- 9.10.6. Энэхүү журмыг мөрдөж ажиллахыг хүлээн зөвшөөрсөн зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдийн ТУЗ-ийн тогтоол;
- 9.10.7. Свитчийн үйл ажиллагааны зөвшөөрөл олгох үйлчилгээний хөлсийг “Монголбанкны үйлчилгээний шимтгэлийн ерөнхий нөхцөл”-ийн дагуу төлсөн баримт;
- 9.10.8. Байгууллагын ТУЗ-өөр баталгаажуулсан эзэмшигчдийн жагсаалт, тэдгээрийн эзэмших хувийн тухай мэдээлэл;
- 9.10.9. Шаардлагатай гэж үзсэн бусад баримт бичиг.
- 9.11. Карт гаргах, хүлээн авах, свитчийн үйл ажиллагаа эрхлэгч нь зөвшөөрөл авахад бүрдүүлсэн картын үйл ажиллагааны журам, заавар, бичиг баримт, гэрээ, техник технологи, програм хангамжид системд нөлөөлөхүйц өөрчлөлт оруулах тохиолдолд өөрчлөлтийн тухай мэдээллийг тухай бүрт нь ирүүлнэ.
- 9.12. Монголбанк нь дараах үндэслэлээр картын үйл ажиллагааны зөвшөөрлийг түдгэлзүүлэх буюу хүчингүй болгоно:
- 9.12.1. Карт эзэмшигч, КУБ-ын төлбөр тооцоог гүйцэтгээгүй, удаа дараа саатуулсан, буруу гүйцэтгэсэн нь тогтоогдсон;
- 9.12.2. Картын үйл ажиллагааны техникийн нууцлал, аюулгүй байдал, тасралтгүй, найдвартай ажиллагааг зохих түвшинд хангаагүй нь тогтоогдсон;
- 9.12.3. Карт хүлээн авагч нь энэ журмын 7-р бүлэгт заасан шаардлагыг өөрийн хамтран ажиллаж байгаа процессороор хангуулаагүй нь тогтоогдсон;

- 9.12.4. ҮЦГТ болон свитчээс тавьсан шаардлагыг удаа дараа зөрчсөн эсвэл биелүүлэхээс татгалзсан нь баримтаар нотлогдсон;
- 9.12.5. Хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр.
- 9.13. Монголбанк дараах үндэслэлээр свитчийн үйл ажиллагааны зөвшөөрлийг түдгэлзүүлэх буюу хүчингүй болгоно:
 - 9.13.1. Гишүүн банкны төлбөр тооцоог гүйцэтгээгүй, удаа дараа саатуулсан, буруу гүйцэтгэсэн нь тогтоогдсон;
 - 9.13.2. Свитчийн үйл ажиллагааны техникийн нууцлал, аюулгүй байдал, тасралтгүй, найдвартай ажиллагааг зохих түвшинд хангаагүй нь тогтоогдсон;
 - 9.13.3. Сүлжээний дүрэм, хамтран ажиллах гэрээг мөрдөж ажиллах тухай гишүүн банкны шаардлагыг удаа дараа хүлээж аваагүй эсвэл биелүүлэхээс татгалзсан нь баримтаар нотлогдсон;
 - 9.13.4. Хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр.
- 9.14. Монголбанк дараах үндэслэлээр карт хүлээн авагчийн процессортой хамтран ажиллах зөвшөөрлийг түдгэлзүүлэх буюу хүчингүй болгоно:
 - 9.14.1. Процессор нь картын төлбөр тооцоог гүйцэтгээгүй, удаа дараа саатуулсан, буруу гүйцэтгэсэн нь тогтоогдсон;
 - 9.14.2. Процессорын үйл ажиллагааны техникийн нууцлал, аюулгүй байдал, тасралтгүй, найдвартай ажиллагааг зохих түвшинд хангаагүй нь тогтоогдсон;
 - 9.14.3. Процессор нь сүлжээний дүрэм, хамтран ажиллах гэрээг мөрдөж ажиллах тухай бусад оролцогчдын шаардлагыг удаа дараа хүлээж аваагүй эсвэл биелүүлэхээс татгалзсан нь баримтаар нотлогдсон;
 - 9.14.4. Хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр.

АРАВ. КАРТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НӨХЦӨЛ, ХҮҮ, ШИМТГЭЛ

- 10.1. Карт гаргагч дараах шимтгэлийг авч болно:
 - 10.1.1. Карт хэвлэсний шимтгэл;
 - 10.1.2. Карт идэвхжүүлэх буюу тэдгээрт өөрчлөлт оруулах шимтгэл;
 - 10.1.3. Үйлчилгээний хураамж;
 - 10.1.4. Холбогдох бусад.
- 10.2. Карт хүлээн авагч дараах шимтгэлийг авч болно:
 - 10.2.1. КУБ-ын шимтгэл;
 - 10.2.2. Банк хоорондын картын бэлэн мөнгөний гүйлгээний шимтгэл (АТМ, ПОБ-оос бэлэн мөнгө авах, г.м үйлчилгээ);
 - 10.2.3. Төрийн үйлчилгээний төлбөрийг дамжуулсны шимтгэл;
 - 10.2.4. Бусад.
- 10.3. Свитч дараах шимтгэлийг авч болно:
 - 10.3.1. Гишүүнчлэлийн шимтгэл;
 - 10.3.2. Банк хоорондын картын гүйлгээний шимтгэл;

10.3.3. Бусад.

- 10.4. Журмын 10.2.1-д заасан шимтгэлийн дээд хязгаар нь 3 хувь, доод хязгаар нь 1 хувь байна.
- 10.5. Журмын 10.2.1, 10.3-д заалтад заасан шимтгэлийг карт эзэмшигч төлөхгүй.
- 10.6. Журмын 10.2.3-т заасан шимтгэлийг “Монголбанкны үйлчилгээний шимтгэлийн ерөнхий нөхцөл”-д заасны дагуу карт эзэмшигч төлнө.
- 10.7. Оролцогч нь шимтгэлийг дараах байдлаар хуваана:
 - 10.7.1. Карт хүлээн авагч нь КУБ-д хийгдсэн гүйлгээний дүнгийн 0.3 хувиас доошгүй хэмжээтэй шимтгэлийг карт гаргагчид төлнө;
 - 10.7.2. Журмын 10.2.3-т заасан шимтгэлийн 30 хувиас доошгүй хэмжээтэй шимтгэлийг карт гаргагчид төлнө.

АРВАН НЭГ. БАНК ХООРОНДЫН КАРТЫН ГҮЙЛГЭЭНД БАРИМТЛАХ СУУРЬ ЗАРЧИМ

- 11.1. Банк хоорондын картын гүйлгээг ҮЦГТ болон свитчээр дамжуулан, бодит цагийн горимд, олон улсын санхүүгийн мэдээний ISO8583 стандартын дагуу гүйцэтгэнэ.
- 11.2. Карт хүлээн авагч нь карт гаргагчаас гүйлгээний зөвшөөрөл өгсний дараа гүйлгээг хийнэ. Зөвшөөрөлгүй хийсэн банк хоорондын картын гүйлгээнээс гарах аливаа эрсдэлийг карт хүлээн авагч хариуцна.
- 11.3. Свитч нь тухайн өдрийн үр дүнгийн тооцооллыг өдөрт нэг буюу түүнээс дээш удаа оролцогчийн Монголбанкн дахь харилцах дансаар харилцан суутгах зарчмаар, төгрөгөөр гүйцэтгэнэ.
- 11.4. Банк хоорондын картын төлбөр тооцоонд Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар тогтоосон их, бага дүнтэй гүйлгээний хязгаар хамаарахгүй бөгөөд гүйлгээний дүнгээс үл хамааран энэ журмаар зохицуулна.

АРВАН ХОЁР. КАРТЫН ТӨЛБӨР ТООЦОО, ҮР ДҮНГИЙН ТООЦООЛОЛ

- 12.1. Оролцогч нь картын гүйлгээг зөвхөн төгрөгөөр илэрхийлж, гүйлгээ дамжуулах өдрийн турш илгээж, дамжуулж, хүлээн авна.
- 12.2. Карт хүлээн авагчтай гэрээ байгуулсан, Монгол Улсад бүртгэлтэй КУБ нь картын төлбөр тооцоог зөвхөн төгрөгөөр гүйцэтгэнэ.
- 12.3. Карт гаргагч, карт хүлээн авагчийн үр дүнгийн тооцооллыг тухайн оролцогчийн Монголбанкн дахь харилцах дансаар харилцан суутгах зарчмаар, төгрөгөөр гүйцэтгэнэ.
- 12.4. Карт хүлээн авагч нь залруулгын гүйлгээтэй холбоотой баримтын бүрдлийг хариуцна.
- 12.5. Залруулгын гүйлгээг буруу гүйцэтгэснээс үүсэх эрсдэлийг карт хүлээн авагч бүрэн хариуцна.
- 12.6. ҮЦГТ нь карт хүлээн авагчаас ирүүлсэн залруулгын хүсэлтийг үндэслэн гүйлгээний мэдээллийг хянаж, зөвшөөрөл олгоно. Уг гүйлгээ нь зөвшөөрөл олгосон өдрийн үр дүнгийн тооцоололд тооцогдоно.

АРВАН ГУРАВ. ҮНДЭСНИЙ ТӨЛБӨРИЙН КАРТ

- 13.1. Үндэсний төлбөрийн картын оноосон нэр нь “₮ карт” буюу “Төгрөг карт” байна. Олон улсад ашиглах нэр нь “₮ card” байна.

- 13.2. Журмын 6 дугаар хавсралтад заасны дагуу ₮ картын загвар буюу картын хэмжээ, нүүрэн тал болон ар талд байх мэдээллийг байршуулна.
- 13.3. Монголбанк нь карт гаргагч банк бүрт БИН дугаар олгоно, ашиглалтад хяналт тавина. БИН дугаарыг MNS ISO/IEC 7812-1, MNS ISO/IEC 7812-2 болон ISO3166 стандартын дагуу 7 дугаар хавсралтад зааснаар олгоно.
- 13.4. ₮ картын лого, түүний байршлыг 8 дугаар хавсралтад зааснаар байрлуулна.
- 13.5. ₮ картын холограмын загвар, түүний байршлыг 9 дүгээр хавсралтад зааснаар байрлуулна.
- 13.6. ₮ картан дээр байрших ҮЦГТ-ийн лого, түүний байршлыг 10 дугаар хавсралтад зааснаар байрлуулна.
- 13.7. Карт гаргагч, карт хүлээн авагч нь ₮ карт болон түүнтэй холбоотой гарын авлага, сурталчилгаанд 8 дугаар хавсралтын 1.1, 1.2 болон 10 дугаар хавсралтын 1.1, 1.2-т заасны дагуу ₮ картын лого, ҮЦГТ-ийн логог ашиглана.
- 13.8. Карт гаргагч нь ₮ картын биет загварыг Монголбанкинд ирүүлж баталгаажуулна.
- 13.9. Монголбанк нь ₮ картын үйл ажиллагаанд мөрдөх шаардлага, үйл ажиллагааны заавар, журмыг батална.
- 13.10. Карт гаргагч нь Монголбанкны зөвшөөрөлтэйгөөр олон улсын картын үйл ажиллагаа эрхлэгч байгууллагатай хамтран “Хосолсон ₮ карт” гаргаж болно.
 - 13.10.1. “Хосолсон ₮ карт”-д олон улсын картын үйл ажиллагаа эрхлэгч байгууллагаас олгосон БИН дугаар ашиглаж болно.
 - 13.10.2. Монголбанк нь “Хосолсон ₮ карт”-аар хийсэн гүйлгээнээс үйлчилгээний шимтгэл авч болно.

АРВАН ДӨРӨВ. ТАСРАЛТГҮЙ, НАЙДВАРТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 14.1. Оролцогч нь Монголбанкнаас баталсан холбогдох журмын дагуу картын системийн тасралтгүй, найдвартай үйл ажиллагааг хангаж ажиллана.
